

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ ТӨҮГ-ЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож хэвшүүлэхэд энэхүү дүрмийн зорилго нь оршино.

1.2. Энэхүү дүрмийг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан бүр өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлах үүрэгтэй байна.

1.3. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгаж дүгнэлт гаргахад энэхүү дүрмийг баримтална.

Хоёр. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтны баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ

2.1. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шударгаар гүйцэтгэх зарчим баримтлана.

2.2. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ төр, засаг болон удирдах байгууллагын бодлого, шийдвэрийг мушгин гуйвуулахгүй байх, Иргэд, харилцагч нарт үйлчилгээ үзүүлэх ажлыг нэн тэргүүний үүргээ гэж үзнэ.

2.3. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын дүрмийг сахин биелүүлж хамт олны эв нэгдлийг хангаж, бэхжүүлж ажиллана.

2.4. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан ардчилсан ил тод, шударга байх болон хамтын удирдлагын зарчмыг чанд баримталж, ажлаа тайлагнаж байна. Шийдвэр гаргах үед дэмжсэн, эс дэмжсэнээс үл хамааран олонхоор гаргасан шийдвэрийг хүндэтгэн дагаж мөрдөнө.

2.5. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан төрийн болон олон нийтийн байгууллагад хүлээсэн сонгуульт үүргээ гүйцэтгэхдээ үүрэгт ажилдаа хүндэтгэлтэй хандаж, авилга, хээл хахуулиас ангид байна.

2.6. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан аливаа асуудалд төвийг сахиж, байгууллагын үзэл баримтлалын талаар бусдад буруу ташаа ойлголт төрүүлэхээс зайлсхийнэ.

2.7. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан бусадтай харилцахдаа ялгаварлал гаргалгүй тэгш хүндэтгэлтэй хандана.

2.8. Хувийн зүгээс явуулж буй аливаа үйл ажиллагаандаа байгууллагын нэр хүндийг ашиглахаас зайлсхийж, зөвхөн иргэний байр сууринаас хандана.

2.9. Ирсэн санал гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулж, хүнд суртал чирэгдэл гаргахгүй ажиллана.

2.10. Хөдөлмөрийн харилцааны зөрчил дутагдлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэлгүй нуун дарагдуулахыг хориглоно.

2.11. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан байгууллагын аль ч шатны эрх мэдлийг шударга бус замаар авах аливаа оролдлого гаргахыг цээрлэнэ.

2.12. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан нэгдсэн шийдвэрт хүрээгүй, дүрмийн хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлыг нийтэд мэдээлэхийг хориглоно.

2.13 Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтан хэн нэгнийг үзэл бодлоо илэрхийлсний төлөө хавчин гадуурхах, байгууллага болон хувь хүний нэр төрийг нь гутаан доромжлох, гүтгэх, дарамтлах, заналхийлэх, эрх мэдлээр далайлгах аливаа илрэл гаргахыг хориглоно.

2.14.Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх болон албан үүргээ гүйцэтгэх үедээ согтуу байхыг хориглоно.

2.15.Албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн программ хангамж болон албаны мэдээллийг ашиглахыг хориглоно.

2.16.Байгууллагаас зохион байгуулсан хурал, уулзалт ярилцлага зэрэг зохион байгууллалттай арга хэмжээнд идэвхтэй оролцож байна.

Гурав. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтны ёс зүйн дүрмийн хяналт, хариуцлага

3.1.Энэхүү ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд байгууллагын дотоод журам,дүрэм, Хөдөлмөрийн тухай хуулинд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын ажилтны талаар эрх ашиг нь зөрчигдсөн этгээдээс бичгээр ирүүлсэн гомдлыг үндэслэн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар байгууллагын хяналтын асуудал эрхэлсэн комисс дүгнэлт гаргаж, гомдол гаргагчид хариу өгнө.

3.3.Хяналтын асуудал эрхэлсэн комисс нь ёс зүйн зөрчлийн талаарх дүгнэлтийг байгууллагын удирдлагад хүргүүлэх ба дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээнд хяналт тавина.

